



ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛГЭГЧ АГЕНТЛАГ

БОЛОВСРОЛЫН ГАЗАР

Эв нэгдэл-1, 116 "а" 6 дугаар баг
Хэрлэн сум, Дорнод аймаг 21071

Утас: 7058-3674

Цахим шуудан: domod@ifrd.mn

Цахим хуудас: domodedu.mn

2026.06.18 № 298

Танай _____-ны № _____-т

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА**

Тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын шалгалтаар ирүүлсэн зөвлөмж,
албан шаардлагын биелэлтийг хүргүүлэв.

Хавсралт: 2 хуудастай



ДАРГА

Ц.АРИУНАА

БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГЫН БИЕЛЭЛТ

2026.06.11

ДД	Зөвлөмж, албан шаардлагын утга	Зөвлөмжийн тоо	Зөвлөмжийн дүн /мян төгрөгөөр/	албан шаардлагын тоо	албан шаардлагын дүн /мян төгрөгөөр/	Тайлбар
1	Байгууллагын батлагдсан орон тоо нь 2026 онд өөрчлөгдөөгүй хэвээр байна. Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэрлүүлэх чиглэл"-д "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	0.00			Тус байгууллага нь 2025 онд 34 орон тоо батлагдсанаас 27 орон тоотойгоор ажилласан, 7 орон тоо дутуу ажилласан. 2025 онд тэтгэвэрт гарсан 2 албан хаагчын сул ажлын байранд ажигтан авч ажиллуулаагүй. 2026 онд 34 орон тоо батлагдсанаас 26 орон тоотойгоор ажиллаж байна. Цаашид хууль журмын дагуу ажиллана
2	Сум орон нутагт эхний таван жил болон дараагийн гурван жил ажилласан ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгүүдийн 396 ажилтанд 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжид олгосон 3,299.4 сая төгрөгөөс хувь хүний орлогын албан татвар 329.9 сая төгрөгийг суутган тооцоолуу			1.0	329,940.0	Үндэсний аудитын газрын 2026 оны 06 сарын 05 ны өдрийн 02/1416 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна. Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-г "Сум, баг, тосгон дахь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, эмч, хоол зүйч, тогооч, багш, багшийн туслах, сэтгэл зүйчид эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгох" гэж заасан тэтгэмж нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-д "хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцаалтгүй тусламж" гэж заасан албан татвараас чөлөөлөх орлогод хамаарахаар байна.

Биелэлт гаргасан: Нягтлан бодогч

Хянасан: Дарга

Д.Балжинням

Ч.Ариунаа





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Т.НЯМ-ОЧИР
ТАНАА

2026.06.05 № 02/1416
танай _____ -ны № 02/2857 -т

Хариу хүргүүлэх тухай

Таны 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн "Чиглэл хүсэх тухай" 02/2857 дугаар албан бичигтэй танилцлаа.

Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-т "сум, баг, тосгон дахь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, эмч, хоол зүйч, тогооч, багш, багшийн туслах, сэтгэл зүйчид эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгох" гэж заасан тэтгэмж нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-д "хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж" гэж заасан албан татвараас чөлөөлөх орлогод хамаарахаар байна.

Иймд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын "Зөрчил арилгах тухай" 30А1170310, ДоА-2026/123/НА-СТА-ТШЗ дугаартай албан шаардлагыг хянаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно.

Хувийг: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



З.ЦЭДЭНЖАВ